



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтыг шинэчлэн
батлах тухай**

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 15.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүн”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН

11741205 902310111

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 131 дүгээр тогтоолын хавсралт

Засгийн газрын 2022 оны 9 дугаар сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 17 дугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын Шадар сайд
- Дэд дарга: -Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга;
-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч.
- Гишүүд: -Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний бөхийн салбар хорооны дарга;
-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хурдан морины салбар хорооны дарга;
-Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд, Үндэсний сурын салбар хорооны дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шагайн харвааны салбар хорооны дарга;
-Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Урлаг, соёлын арга хэмжээний салбар хорооны дарга;
-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны дарга;
-Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар хорооны дарга;
-Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооны дарга;

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга;
- Соёлын сайд;
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга (зөвшилцсөнөөр);
- Төв аймгийн Засаг дарга;
- Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх;
- Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Стандарт, хэмжил зүйн газрын дарга;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга;
- Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга;
- Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга;
- Биеийн тамир, спортын улсын хорооны дарга;

-Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн
хүрээлэнгийн захирал;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн газрын дарга.

Нарийн бичгийн
дарга:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.

---oO---